

**“ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН 56 ДУГААР ЗҮЙЛД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Монгол Улсын авто замын хэвтээ тэнхлэгийн зүүн чиглэл болох Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай замын Цагаан хоолой гэдэг газрын нийт 50 км замыг улсын комисс хүлээж аваагүй, замын эвдрэл, гэмтэл их байгаагаас шалтгаалан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэлд орж байгаа тухай, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин 2022 онд Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрдөг нислэг буурснаас үүдэн навигацийн ашиг, орлого буурсан эсэхийг ажлын хэсгээс тодруулж асуулт асуусан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Дорнод аймгийг Улаанбаатар хот, бусад аймагтай холбох улсын чанартай гол замын чанар, стандартад анхаарч ажиллах тухай, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Говь-Алтай аймгийн Цээл сумын нутгаар дайрах агаарын хаалгыг нээх, Дундад Азиар дамжин зүүн хойд зүгт Хятадын Шинжаан-Уйгар-Манжуурын чиглэлд болон “Хайнань-Шанхай чиглэлд “МИАТ” ХХК-наас нислэг хийх тухай асуудлыг анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн болно.


Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, 75 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Канад Улсын Монреаль хотод 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг